



**ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2018 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 0115

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.2, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, “Үүрэг трейд” ХХК болон “Хурдны зам” ХХК-тай байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний тусгай нөхцлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зам, тээврийн хөгжлийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 03/800, 03/801 тоот албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн барилгын ажил, Завхан аймаг дахь “Доной” нисэх буудлын хөөрч буух хучилттай зурвасын ажлыг үргэлжлүүлэн хийлгэхээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар гүйцэтгэгч байгууллагуудтай хэлцэл хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга:	Т.Батжаргал	Захиргаа, удирдлагын газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Ч.Болдбаатар	Худалдан авах ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн
	П.Сүхболд	Худалдан авах ажиллагааны хэлтсийн аэродромын инженер
Гишүүд:	Н.Мөнхсүрэн	Дотоод аудитын албаны дарга
	Ё.Эрдэнэбат	Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга
	Д.Эрдэнэбаатар	Нисэх буудлуудын бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга
	Ч.Нямсүрэн	Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга
	Б.Батхишиг	Худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга
Д.Эрдэнэцогт	Аж ахуйн тасгийн менежер	


Б.Солонго	Захиргаа, удирдлагын газрын хуулийн мэргэжилтэн
Б.Мөнхбат	Захиргаа, удирдлагын газрын захиргааны мэргэжилтэн
Ж.Билэгсайхан	Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх захиргааны албаны барилгын хяналтын инженер

2. Барилгын ажлын гүйцэтгэгч компаниудтай байгуулсан үндсэн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээний төслийг бэлдэж, холбогдох хууль тогтоомжийн дагуу ажиллахыг Ажлын хэсэг /Т.Батжаргал/-т үүрэг болгосугай.

3. Гэрээ байгуулах ажлын явцыг Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын зөвлөл хуралдах бүрт зөвлөлийн гишүүдэд танилцуулж байхыг Дотоод аудитын алба /Н.Мөнхсүрэн/, Худалдан авах ажиллагааны хэлтэс /Б.Батхишиг/-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн А/453 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН